

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**



**УЛСЫН ХӨГЖЛИЙН  
2027 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ**

**Улаанбаатар хот**

**2026 он**

## САНАЛ, ДҮГНЭЛТ

Монгол Улсын Засгийн газраас Үндсэн Хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад “Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна.”, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт “Засгийн газар Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 05 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Улсын Их Хурал 06 дугаар сарын 01-ний дотор батална.” гэж тус тус заасны дагуу “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө”-ний төслийг боловсруулсан “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-тэй уялдуулан дараах байдлаар боловсруулсан байна:

Д/д	Бодлогын чиглэл	Үндэсний үр дүн	Салбарын үр дүн	ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Төсөл, арга хэмжээ
1	Хүний хөгжил	1. Хүний хөгжлийн түвшнийг нэмэгдүүлнэ.	2	5	19	41
		2. Дундаж давхаргыг нэмэгдүүлнэ.	2	4	7	9
2	Нийгмийн хөгжил, үндэсний нэгдмэл үнэт зүйл	3. Үндэсний нэгдмэл үнэт зүйлсийг бэхжүүлнэ.	1	2	5	7
		4. Нийгмийн сайн сайхан байдлыг дээшлүүлнэ.	4	11	28	48
3	Эдийн засаг, дэд бүтцийн хөгжил	5. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хадгална.	8	11	22	88
4	Байгаль орчин, ногоон эдийн засаг	6. Байгаль орчны тогтвортой байдлыг хадгална.	3	5	17	32
5	Төрийн бүтээмж, засаглал	7. Зөв засаглалын үзүүлэлтийг нэмэгдүүлнэ.	7	19	38	48
6	Бүсийн хөгжил	8. Бүс, орон нутгийн хөгжлийн ялгааг багасгана.	1	2	10	16
7	Үндэсний өрсөлдөх чадвар	9. Монгол Улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.	3	6	9	14
8	Шинжлэх ухаан, технологи, хиймэл оюун	10. Эдийн засаг, нийгмийн хөгжилд үзүүлэх шинжлэх ухаан, технологи, инновацын хувь нэмэр, оролцоог нэмэгдүүлнэ.	2	2	4	7

Үндэсний аудитын газар Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8.1-д заасан чиг үүргийн хүрээнд Улсын хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд жил бүр аудит хийж, хөгжлийн төлөвлөгөөг хуулийн шаардлагад нийцүүлэн боловсруулах, шалгуур үзүүлэлт оновчгүй, суурь болон зорилтот түвшин хэмжигдэхүйц бус арга хэмжээ төлөвлөхгүй байх талаар дүгнэлт, зөвлөмж хүргүүлж ирсэн.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг тэргүүлэх чиглэл, хөтөлбөр болон төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны үр дүн, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-д заасан аргачлалын дагуу үнэлэхэд бодлогын 4 тэргүүлэх чиглэлийн 6 шалгуур үзүүлэлтийн дундаж үнэлгээ 20.9 хувь, Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны 29 үр дүнгийн 47 шалгуур үзүүлэлтийн дундаж үнэлгээ 63.7 хувь, Хэрэгжүүлэх хөтөлбөрийн 63 үр дүнгийн 91 шалгуур үзүүлэлтийн дундаж үнэлгээ 62.0 хувь, Төлөвлөсөн нийт 328 төсөл, арга хэмжээний 373 шалгуур үзүүлэлтийн дундаж үнэлгээ 58.1 хувьтай байсан.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд аудит хийж Эдийн засаг, хөгжлийн сайдад хөгжлийн төлөвлөгөөг хуулийн шаардлагад нийцүүлэн боловсруулах чиглэлээр 2 зөвлөмж, Сангийн сайдад улсын төсвийг хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглүүлэх талаар 1 зөвлөмж, төсвийн ерөнхийлөн захирагч нарт улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагналыг сайжруулах чиглэлээр 3 зөвлөмж, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлэх чиглэлээр 1 зөвлөмж, нийт 7 зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж, хэрэгжилтийг нь ханган ажилласнаар төлөвлөлтийн алдаа бага гарч, улмаар хэрэгжилтэд ч эерэг нөлөө үзүүлэх чухал ач холбогдолтой гэж дүгнэсэн.

Улсын хөгжлийн төлөвлөгөөнд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу шалгуур үзүүлэлтийг тэргүүлэх чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн болон хөтөлбөрийн үр дүн, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үе шат бүрд тоон болон чанарын үзүүлэлтээр хэмжих, салбар хооронд нэгтгэн удирдах шаардлагыг заасан боловч шалгуур үзүүлэлт оновчгүй, хэмжих нэгж уялдаагүй, суурь болон зорилтот түвшин хэмжигдэхүйц бус, алдаатай тодорхойлсон зэрэг төлөвлөлтийн алдаа, зөрчлүүд Үндэсний аудитын газраас гүйцэтгэсэн аудитаар давтагдсаар байгааг хөгжлийн төлөвлөгөө боловсруулахдаа алдаа, дутагдлыг засч, хэрэгжилтийг хангаж ажиллахыг зөвлөж байна.

Үндэсний аудитын газраас гүйцэтгэсэн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн аудитын дүн, дүгнэлтдээ үндэслэн Монгол Улсын тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төслийг боловсруулахдаа анхаарах саналыг өмнө нь хүргүүлсэн.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний санхүүжилтийн эх үүсвэрийг тооцоо судалгаанд үндэслээгүй, хуульд заасан шаардлага нийцүүлэн төсөвлөөгүйгээс төлөвлөгөөний хэрэгжилтэд нөлөөлж, зорилтот түвшинд хүрэхгүй байх үр дагавар гарч байгаад дүгнэлт хийж, төсөл арга хэмжээний эх үүсвэр, төсвийн тооцооллыг бодитой тооцож төлөвлөх нь зүйтэй байна.

Улсын хөгжлийн төлөвлөгөөний төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан зарчмыг баримталж, төлөвлөлтийг судалгаа, тооцоонд үндэслэх, шалгуур үзүүлэлтийг тэргүүлэх чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн болон хөтөлбөрийн үр дүн, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үе шат бүрд тоон болон чанарын үзүүлэлтээр хэмжигдэхүйц, төлөвлөлтийг үр дүнд чиглүүлэхэд анхаарна уу.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн богино хугацааны бодлогын баримт бичгийг төлөвлөхдөө хэрэгжилт, үр дүнг хангахад чиглэсэн санхүүжилтийн эх үүсвэр, шаардлагатай хөрөнгийг тооцоолох, үр дүнд суурилсан төсөвлөлт, төлөвлөлтийг хийхэд чиглүүлэх шаардлагатай юм.

Хөгжлийн жилийн төлөвлөгөөнд төлөвлөсөн тэргүүлэх чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн болон хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтэд үндэсний статистик болон олон улсын байгууллагын гаргадаг үзүүлэлт, тайлангийн гарах болон тархаах хугацаа, зарим индексийг батлан гаргаагүйгээс арга хэмжээний үр дүнг үнэлэх боломжгүй байдалд хүрэх эрсдэлтэй байгааг анхаарах нь зүйтэй.

Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 8.1.2-т “урьдчилсан үнэлгээ хийсэн, түншлэлээр хэрэгжүүлэх төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд

заасны дагуу урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах” гэж заасныг баримтлах шаардлагатай байна.

Монгол Улсын хөгжлийн жилийн 2027 оны төлөвлөгөөний төслийг Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуультай нийцүүлэн түүвэрлэн үзэхэд дараах асуудлууд байна. Тухайлбал:

- Хөгжлийн жилийн төлөвлөгөөнд төлөвлөсөн бодлогын чиглэл, үндэсний, салбарын, төсвийн ерөнхийлөн захирагчийн болон хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтэд үндэсний статистик болон олон улсын байгууллагын гаргадаг үзүүлэлт тайлангийн гарах болон тархаах хугацаанаас шалтгаалж зарим арга хэмжээний үр дүнг үнэлэх боломжгүй байдалд хүрэх эрсдэлтэй байгааг анхаарах; *(Тухайлбал, 15 настай суралцагчдын суурь чадвар, Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт, Үндэсний хөтөлбөрт тусгагдсан бүх төрлийн вакцинжуулалтад хамрагдсан зорилтот хүн амын эзлэх хувь, Хөдөлмөр эрхэлж байгаа боловч ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн амын хувийн жин, Ядуурлын хамралтын хүрээ, Нийгмийн хамгааллын суурь хөтөлбөрт хамрагдсан хүн амын эзлэх хувь /ядуу хүн ам/, 15 ба түүнээс дээш насны хүн амын дундах эрэгтэйчүүдийн /15-49 нас/ тамхи таталтын тархалт, Аялал жуулчлалын хөгжлийн индекс, Логистикийн гүйцэтгэлийн индекс, Байгаль орчны гүйцэтгэлийн индекс, хүлэмжийн хийн ялгарлын бууралт, Нэн хүчтэй, хүчтэй доройтсон газар нутгийн эзлэх хувь, Нээлттэй өгөгдлийн үнэлгээ /ODIN/, хиймэл оюуны ёс зүйн бэлэн байдлын үзүүлэлт)*
- Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төсөлд тусгагдсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу салбарын, үндэсний, төсвийн ерөнхийлөн захирагчийн болон хөтөлбөрийн үр дүн, төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн суурь болон зорилтот түвшин хэмжигдэхүйц бус, ижил агуулгаар тусгагдсан байгааг анхаарч үзэх нь зүйтэй байна. *(Жагсаалтыг хавсаргаав.)*

Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төслийг хэлэлцэн батлахдаа анхааралдаа авах дараах саналыг толилуулж байна. Үүнд:

1. Улсын хөгжлийн төлөвлөгөөнд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан зарчмыг баримталж, төлөвлөлтийг судалгаа, тооцоололд үндэслэх, шалгуур үзүүлэлтийг тэргүүлэх чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн болон хөтөлбөрийн үр дүн, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үе шат бүрд тоон болон чанарын үзүүлэлтээр хэмжигдэхүйц, төлөвлөлтийг үр дүнд чиглүүлэн боловсруулах;
2. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн богино хугацааны бодлогын баримт бичгийг төлөвлөхдөө хэрэгжилт, үр дүнг хангахад чиглэсэн санхүүжилтийн эх үүсвэр, шаардлагатай хөрөнгийг бүрэн тооцоолох, үр дүнд суурилсан төсөвлөлт, төлөвлөлтийг хийх;
3. Хөгжлийн жилийн төлөвлөгөөнд төлөвлөсөн тэргүүлэх чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн болон хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтэд үндэсний статистик болон олон улсын байгууллагын гаргадаг үзүүлэлт тайлангийн гарах болон тархаах хугацаа, зарим индексийг батлан гаргаагүйгээс арга хэмжээний үр дүнг үнэлэх боломжгүй байдалд хүрэх эрсдэлтэй байгааг анхаарах;

4. Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 8.1.2-т “урьдчилсан үнэлгээ хийсэн, түншлэлээр хэрэгжүүлэх төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах” гэж заасныг баримтлах;
5. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа мэдээ, мэдээлэл, өгөгдөлд дүн шинжилгээ хийж төлөвлөгөөний гүйцэтгэлд нөлөөлөх шалтгаан, эрсдэлт хүчин зүйлийг тодорхойлж, үнэлэн, эрсдэлийн суурь судалгааг боловсруулан төлөвлөх.

Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг төлөвлөх, тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр баталсан холбогдох хууль, журмын цаглаварт хугацаанд дүн шинжилгээ хийж, бүх талуудын оролцоог жигд хангаж, Үндэсний аудитын газраас хүргүүлсэн санал, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн хэлэлцүүлгийн явцад төлөвлөгөөний төслийн шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, санхүүжилтийн эх үүсвэр, түүний тооцоололд сайжруулалт хийх шаардлагатай байна.

---oO---

Үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн суурь болон зорилтот түвшинг өөрчлөлтгүй буюу ижил утгаар тусгасан:

### Салбарын үр дүн

Д/д	Үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	Зорилтот түвшин 2027 он	Хариуцах байгууллага
1	7.7 Батлан хамгаалах чадавхыг бэхжүүлнэ.	Батлан хамгаалах чадавхын индекс	Индекс	2025	1.99	1.99	Батлан хамгаалах яам

### Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн

Д/д	Үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	Зорилтот түвшин 2027 он	Хариуцах байгууллага
1	7.2.1 Хүний эрх, эрх чөлөөний хамгаалалтыг сайжруулна.	Дэлхийн эрх чөлөөний индекс	Эрэмбэ	2024	84	84	Хууль зүй, дотоод хэргийн яам
2	7.6.1 Олон улсад Монгол Улсын нэр хүндийг өсгөнө.	Дээд, өндөр түвшний айлчлалын тоо	Тоо	2024	21	21	Гадаад харилцааны яам

### Хөтөлбөрийн үр дүн

Д/д	Үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	Зорилтот түвшин 2027 он	Хариуцах байгууллага
1	1.1.1 5 настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг сайжруулна.	Сургуульд элсэн орохын өмнөх нэг жилд зохион байгуулалттай сургалтад хамрагдалт	Хувь	2025	96.0	96.0	Боловсролын яам
2	1.1.3.1 Хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадвартай мэргэжлийн болон техникийн боловсролтой төгсөгчдийг нэмэгдүүлнэ.	КООСЭН хөтөлбөр хэрэгжүүлж байгаа политехник коллеж	Тоо	2025	4	4	Боловсролын яам
3	4.2.1.1 Улс төрийн болон бодлого боловсруулах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.	УИХ, орон нутгийн эрх барих хуралд суудалтай эмэгтэйчүүдийн эзлэх хувь	Хувь	2024	27.6	27.6	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар

4	5.3.1.1 Малын халдварт, гоц халдварт, архаг халдварт болон зооноз халдварт өвчний гаралтыг бууруулна.	Олон улсын худалдааны хоригтой үхрийн цээж, үхрийн тархи сархиатах, үхрийн сүрьеэ, лейкоз, адууны африк мялзан, хонины скрепи өвчний гаралтын тоо	Тоо	2024	0	0	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
5	5.7.2.2 Идэвхтэй ажиллагаатай боомтын тоог нэмэгдүүлнэ.	Идэвхтэй ажиллагаатай боомтын тоо	Тоо	2024	24	24	Сангийн яам
6	6.3.1.5 Хөрс болон доройтсон бэлчээрийг хамгаалж, нөхөн сэргээлтийг нэмэгдүүлнэ.	Цөлжилтийг бууруулах, хамгаалах арга хэмжээ авсан газар нутгийн хэмжээ, тухайн жилд	Га	2025	200	200	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
7	9.2.1.2 Урсгал дансны алдагдлыг үе шаттай бууруулна.	Нефтийн бүтээгдэхүүний хэрэглээг дотоодын үйлдвэрлэлээр хангах	Хувь	2025	0	0	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам

### Төсөл, арга хэмжээ

№	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Үр дүнгийн үзүүлэлт			Хариуцах байгууллага
				Суурь он	Суурь түвшин	Зорилтот түвшин	
1	1.1.3.2.2. Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал, зэрэглэл, чиг үүрэг, түвшний ялгааг тодорхой болгож, шалгуур үзүүлэлтийг шинэчлэн сургууль бүрд жигд хэрэгжүүлэх	Ангилалд хамрагдсан дээд боловсролын сургалтын байгууллага	Тоо	2025	68	68	Боловсролын яам
2	5.1.2.2.1. Цагаан алт хөдөлгөөний хүрээнд ноос, ноолуур, арьс ширний бэлтгэл, үйлдвэрлэл, экспортыг дэмжсэн эргэлтийн хөрөнгийн зээл, зээлийн хүүгийн дэмжлэг үзүүлэх	Дэмжлэгт хамрагдаж хүчин чадал нь нэмэгдсэн аж, ахуй нэгж	Тоо	2025	93	93	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам
3	5.1.2.2.2. Шинэ, дэвшилтэт технологи бүхий ноолуурын зэрэх үйлдвэрийн хөрөнгө оруулалтын зээл, зээлийн хүүгийн дэмжлэг үзүүлэх	Дэмжлэгт хамрагдаж хүчин чадал нь нэмэгдсэн аж, ахуй нэгж	Тоо	2025	17	17	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам
4	5.1.2.2.3. Арьс ширийг боловсруулах үйлдвэрлэлд хөрөнгө оруулалтын зээл, зээлийн хүүгийн дэмжих үзүүлэх	Дэмжлэгт хамрагдаж хүчин чадал нь нэмэгдсэн аж, ахуй нэгж	Тоо	2025	15	15	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам

5	5.1.2.2.4.Шинэ, дэвшилтэт технологи бүхий ноос боловсруулах үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтын зээл, зээлийн хүүгийн дэмжлэг үзүүлэх	Дэмжлэгт хамрагдаж хүчин чадал нь нэмэгдсэн аж, ахуй нэгж	Тоо	2025	24	24	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам
6	5.2.1.1.6.Үнэт, өнгөт, хар, ховор, холимог металл болон металл бус ашигт малтмалын эрэл, үнэлгээний ажил хийх	Хэрэгжүүлсэн төсөл	Тоо	2025	2	2	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
7	5.2.1.2.1.Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг нэмэгдүүлж, хайгуулын ажлыг эрчимжүүлэн геологийн нөөцийг өсгөх	Хайгуулын тусгай зөвшөөрөл	Тоо	2025	80	80	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
8	6.1.1.1.2.Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлэх	Бэхжүүлсэн хамгаалалтын захиргаа	Тоо	2025	10	10	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
9	6.3.1.1.2.Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд ойн үрийн нөөцийг бүрдүүлэх	Бүрдүүлсэн үрийн нөөцийн хэмжээ	Кг	2025	1000	1000	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
10	6.3.1.3.1.Ашиглалтад өртөмтгий ургамал, амьтны тархац нөөцийг тогтоох	Тархац, нөөцийг тогтоосон амьтны зүйл	Тоо	2025	3	3	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
11	7.1.1.1.2.Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчлах	Зохион байгуулсан арга хэмжээ	Тоо	2025	10	10	Авлигатай тэмцэх газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
12	7.2.1.2.2.Монгол Улсын түүх соёлд холбогдох гадаад улсад хадгалагдаж байгаа баримтыг эх нутагт нь байршуулж, эдийн засгийн эргэлтэд оруулах	Хамтран ажилласан улс	Тоо	2025	2	2	Хууль зүй, дотоод хэргийн яам
13	7.3.4.3.1.Төрийн өмчит компанийн засаглал, ил тод байдлыг сайжруулах	Олон нийтийн хяналтад оруулсан төрийн өмчит компани	Тоо	2025	2	2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
14	7.4.1.1.2.Олон улсын жишиг загварын дагуу Парламентын боловсрол олгож, сурталчлан таниулах	Хамрагдсан оюутан	Тоо	2025	100	100	Улсын Их Хурлын Тамгын газар
15	7.4.2.2.1.Тооллого, түүвэр судалгаа зохион байгуулах	Арга хэмжээний хэрэгжилт	Хувь	2025	100	100	Үндэсний статистикийн хороо
16	7.5.1.1.1.Сонгуулийн автоматжуулсан системийг шинэчлэх	Тоног төхөөрөмж /Старлинк төхөөрөмж иж бүрдлийн хамт/	Тоо	2025	600	600	Сонгуулийн ерөнхий хороо

17	7.6.1.1.1."Хүчирхэг Монгол паспорт" бодлого хэрэгжүүлэх	Визгүй зорчих хэлэлцээр хийхээр хүргүүлсэн санал	Тоо	2025	2	2	Гадаад харилцааны яам
18	7.6.2.1.1."Монгол өв ба дэлхий дахин төлөвлөгөө" хэрэгжүүлэх	Олон улсад гаргасан үзэсгэлэн, тоглолт	Тоо	2025	1	1	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Гадаад харилцааны яам
19		"Дэлхийд тархсан Монгол өв" ном бүтээх	Тоо	2025	1	1	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
20	9.2.1.1.1.Төсвийн урсгал зардлыг зохистой түвшинд хязгаарлах	-	-	-	-	-	Эдийн засаг, хөгжлийн яам